

БАТЛАВ: ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА

Г.ЧИНЗОРИГ /...../
Гарын үсэг/

БАТЛАВ: “ЭМ ЭМ СИ ЖИ”
ЗАХИРАЛ

Д.БУМ-ЭРДЭНЭ /...../
Гарын үсэг/

“ИНТЕРНЭТИЙН ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СУУРЬ СУДАЛГАА ХИЙХ”

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

Гэрээний дугаар №: ХХЗХ/202112034

2020 оны 05-р сарын 21- ны өдөр
хот

Улаанбаатар

Энэхүү Үйлчилгээ үзүүлэх гэрээг нэг талаас Харилцаа холбооны зохицуулах хороо, түүнийг төлөөлж Захиргаа удирдлага хамтын ажиллагааны газрын дарга З.Эрдэнэчулуун /цаашид Захиалагч гэх/, Нөгөө талаас “Эм Эм Си Жи ” ХХК, түүнийг төлөөлж Д.Бум –Эрдэнэ /цаашид Гүйцэтгэгч гэх/ нар дараах зүйлийг харилцан тохиролцож 2021 оны 05 сарын 21-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Гүйцэтгэгч (Гүйцэтгэгч) нь энэхүү гэрээ болон гэрээний салшгүй хэсэг болох Хавсралт № 1-д тодорхойлсон “Ажлын даалгавар болон үйлчилгээний цар хүрээ”-нд заасан Гүйцэтгэгч үйлчилгээг (цаашид “үйлчилгээ” гэх) үзүүлэх үүрэгтэй.
2. Гүйцэтгэгч нь захиалагчаас шаардаж буй мэргэжлийн дадлага туршлага, ажиллах хүчин болон техникийн эх үүсвэртэй бөгөөд гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу үйлчилгээг үзүүлэхийг хүлээн зөвшөөрсөн болно.
3. Захиалагч нь “Интернэтийн зохистой хэрэглээ, мэдээллийн технологийн аюулгүй байдлын суурь судалгаа хийх” ХХЗХ/202112034 үйлчилгээг (цаашид “ажил” гэх) 49,973,000 төгрөг [Дөчин есөн сая есөн зуун далан гурван мянга] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн Гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
4. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:


Гэрээний ерөнхий нөхцөл;

Гэрээний тусгай нөхцөл;

Хавсралт

Хавсралт №1 Ажлын даалгавар, үйлчилгээний цар хүрээ

Зөвлөх үйлчилгээний тодорхойлолт



Хавсралт №2 Тайлан гаргах хуваарь

Хавсралт №3 Голлох мэргэжилтэн болон туслан гүйцэтгэгч

Хавсралт №4. Гэрээний үнийн задаргаа (төгрөгөөр)

Хавсралт №5 Төлбөрийн хуваарь (төгрөгөөр)

Гэрээ нь энд дурдсан Гүйцэтгэгч үйлчилгээг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно.

5. Захиалагч болон Гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
6. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
7. Захиалагч нь гэрээний дагуу Гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон цахим шуудан, утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

З.Эрдэнэчулуун
ЗУХАГ-ын дарга
[Гарын үсэг]

ТАМГА

Б.Мягмарнаран
ХАХХ-ийн дарга
[Гарын үсэг]

Д.Нарансолонго
ЗУХАГ-ын мэргэжилтэн
[Гарын үсэг]

Харилцаа холбооны зохицуулах хороо
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Д.Сүхбаатарын гудамж-13,
Метро бизнес төв 5 давхар,
Утас: 304258

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Ч.Даваасүрэн
Эм Эм Си Жи ХХК-ийн судалгаа хөгжил
хариуцсан захирал
[Гарын үсэг]

ТАМГА

П.Тувшинмандох
Эм Эм Си Жи ХХК-ийн БСХ-ийн дарга
[Гарын үсэг]

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
14-р хороо, Энхтайвны өргөн чөлөө,
Зүүн хүрээ хотхон, 203-р барилга, 4 давхар
Утас: 77000188
Харилцагч банк: Худалдаа хөгжлийн банк
Дансны дугаар: 453037955